


Авлигатай тэмцэх газрын
2025 оны 04 дүгээр сарын 30-ний өдрийн
081.834/2 дугаар албан бичгийн хавсралт



АРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

1. Онооны нэгдсэн хүснэгт

№	Арга хэмжээний дугаар	Өөрийн үнэлгээ	Хяналтын үнэлгээ	Дээд шатны үнэлгээ
1.	2.5.2.1	100%	50%	30%
2.	2.6.2.1	100%	Үнэлгээнээс хасаж тооцов.	Үнэлгээнээс хасаж тооцов.
3.	3.2.3.2	100%	50%	50%
4.	3.3.1.4	100%	50%	0%
5.	3.3.1.5	30%	0%	0%
6.	6.4.11.1	90.91%	90%	70%
7.	7.1.2.1	100%	Үнэлгээнээс хасаж тооцов.	Үнэлгээнээс хасаж тооцов.
8.	7.1.2.2	100%	Үнэлгээнээс хасаж тооцов.	Үнэлгээнээс хасаж тооцов.
9.	9.2.1.1	100%	90%	90%
10.	9.2.2.1	100%	70%	70%
11.	9.3.3.1	100%	70%	50%
12.	9.4.2.1	100%	70%	50%
13.	9.4.3.1	100%	30%	30%
14.	9.5.2.1	100%	90%	90%
Дундаж оноо		94.35	64.55	48.2

2. Арга хэмжээний хэрэгжилтийн үнэлгээний дэлгэрэнгүй

Арга хэмжээ	Хэрэгжилт	ӨҮ	Хяналтын үнэлгээ	Дээд шатны үнэлгээ
2.5.2.1. Олон нийтэд нээлттэй, ил тод болгохоор заасан мэдээллийг тухай бүр цахим системд нээлттэй байршуулах	Авлигатай тэмцэх газраас соён гэгээрүүлэх чиглэлээр бэлтгэсэн контентуудыг аймгийн албан ёсны цахим хуудас www.arkhangai.gov.mn , Засаг даргын тамгын газрын фэйсбүүк пэйж хуудас, ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтэс, Засаг даргын хэрэгжүүлэгч 29 агентлаг, 19 сумын албан ёсны цахим хуудас болон фэйсбүүк пэйж хуудаст хуваалцан, байгууллагуудын лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулж, давхардсан тоогоор 50,000 гаруй иргэд, олон нийтэд хүргэсэн.	100%	50% Тайлбар: 1.Засгийн газрын 2022 оны 352-р тогтоолоор батлагдсан журмын дагуу ил тод байдлын шалгуур үзүүлэлтэд хийсэн үнэлгээний тайланг баримт болгож хавсаргаагүй, арга хэмжээний агуулгыг бүрэн тайлагнаагүй, зөвхөн авлигын эсрэг сурталчилсан үйл ажиллагааны баримт гэх зурган мэдээлэл оруулсан нь шалгуур үзүүлэлтэд бүрэн нийцэхгүй.Цахим хуудсуудыг хянаж үзэхэд мэдээлэл хуучирсан, мэдээллийн бүрэн бүтэн байдал, хүртээмжтэй байдал хангалтгүй тул үнэлгээг бууруулав.	30% Тайлбар: - Арга хэмжээний хэрэгжилтийг Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан журмын дагуу үнэлж, албажуулсан тайланг нотломж болгон хавсаргаагүй. - Байгууллагын цахим хуудсанд Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдээллийг бүрэн байршуулаагүй, мэдээлэл хуучирсан. - Арга хэмжээний хэрэгжилтийг Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоолын дагуу үнэлж, тайланг хавсаргаагүй, арга хэмжээтэй холбогдолгүй зүйл тайлагнасан байхад үндэслэл муутай үнэлсэн тул хяналтын үнэлгээг бууруулав.
2.6.2.1. Шударга байдлын үнэлгээгээр хамгийн бага оноо авсан яам, агентлаг, нутгийн захиргааны байгууллагад авлигын эрсдэлийг бууруулах тусгайлсан төлөвлөгөө хэрэгжүүлэх	Аймгийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, аймгийн тамгын газрын Хууль эрх зүйн хэлтэс, аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан болон давж заалдах шатны шүүх, аймгийн прокурорын газар, хууль сахиулах, зөрчил шалгах шийдвэрлэх эрх бүхий байгууллагуудын хамтын ажиллагаа, ажлын уялдаа холбоог сайжруулах, шударга байдлын үнэлгээг нэмэгдүүлэх чиглэлээр санал солилцон, нэгдсэн зөвлөгөөнийг зохион байгууллаа.	100%	Үнэлгээнээс хасаж тооцов. Тайлбар: Шударга байдлын үнэлгээний үр дүнд суурилан авлигын эрсдэлийг бууруулах тусгайлсан төлөвлөгөө хэрэгжүүлээгүй.	Үнэлгээнээс хасаж тооцов. Тайлбар: Шударга байдлын үнэлгээний үр дүнд суурилан авлигын эрсдэлийг бууруулах тусгайлсан төлөвлөгөө хасаж тооцов.
3.2.3.2. Нийтийн сонсголын тухай хуульд заасан сонсголд иргэн, иргэний нийгмийн	Архангай аймаг 2024 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 105,2 тэрбум төгрөгийн 30 төсөл арга хэмжээг шинээр, аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 8,8 тэрбум төгрөгийн 36 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж байна. Дээрх 66 төсөл арга хэмжээний төлөвлөлтийг 2023 онд сум, агентлагийн саналыг авч нэгтгэн, иргэн, иргэний нийгмийн	100%	50% Тайлбар:	50% Тайлбар:

байгууллагын оролцоог нэмэгдүүлэх	байгууллагаас санал авч, ажлын хэсгээс эрэмбэлэн улсын төсөв болон аймаг, орон нутгийн төсөвт тусган хэрэгжүүлж байна. 2025 оны орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтыг Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөнд уялдуулан боловсруулж, 2024 оны 11 дүгээр сарын 20, 21-ний өдрүүдэд салбар байгууллага болон олон нийтэд нээлттэй хэлэлцүүлгийг зохион байгуулан 17 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан.		1.Нийтийн сонсголын тухай хуулийн 8.5, 9.3-т заасан асуудлаар хуульд заасан шаардлагад нийцсэн сонсгол явуулсан эсэх тухай тайлагналд байхгүй, баримт дутуу, шалгуур үзүүлэлтийг хангасан эсэх мэдээлэл байхгүй 2.Хүрэх түвшиндээ хүрээгүй, хүрсэн эсэх асуудлыг тодруулаагүй орхигдуулсан тул үнэлгээг бууруулсан.	Нийтийн сонсголын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5-д заасны дагуу хуульд заасан этгээд “хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын хэрэгжилтийг үнэлэх зорилгоор ерөнхий хяналтын сонсголыг тогтмол явуулах бөгөөд тухайн хууль, тогтоомж, захиргааны хэм хэмжээний акт хүчин төгөлдөр болсноос хойш 24-30 сарын дотор эхний хяналтын сонсголыг, дараагийн сонсголыг таван жил тутамд нэгээс доошгүй удаа заавал зохион байгуулна”. Мөн хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3-д Засгийн газар, төрийн захиргааны төв, нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллага мөн зүйлийн 9.3.1.-9.3.6-д заасан асуудлаар төсвийн хяналтын сонсголыг жил бүр зохион байгуулахаар заасан. Архангай аймгийн ЗДТГ тус арга хэмжээний хэрэгжилтийг тайлагнахдаа гарсан үр дүнг тодотгож, шалгуур үзүүлэлт болох "сонсголд оролцсон ажиглагч, оролцогчдын тооны өсөлт"-ийн талаар тодорхой мэдээлэл, нотлох баримт ирүүлэхэд анхаарах шаардлагатай.
3.3.1.4. Авлигатай тэмцэх зорилго бүхий иргэний нийгмийн байгууллагын сүлжээ, иргэдийн сайн дурын хөдөлгөөнийг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлэх	Архангай аймгийн хуульчдын холбооны салбар зөвлөлтэй хамтран “Хуульчийн Про Боно өдөрлөг”-ийг зохион байгуулсан. Өдөрлөгийн үеэр иргэдэд 9 төрлийн 200 гаруй гарын авлага, брошюрыг, төрийн байгууллагын удирдлагуудад 5 төрлийн 20 номыг тараан авлигын эсрэг үйл ажиллагааг сурталчлан таниулсан. Өдөрлөгт давхардсан тоогоор 3000 гаруй иргэд хамрагдсан. Иргэд, олон нийтэд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулсан.	100%	50% Тайлбар: 1.ИНБ болон иргэдийн сайн дурын хөдөлгөөнийг дэмжсэн эсэх, хөтөлбөр хэрэгжүүлсэн гэх мэдээлэл байхгүй. Хуульчдын холбооноос төлөвлөгөөнийхөө дагуу хийдэг ажлаар орлуулан тайлагнасан. Шалгуур	0% Тайлбар: АТҮХ-т "Төрийн үйл ажиллагаанд хараат бус хөндлөнгийн хяналт тавих иргэний нийгмийн байгууллагыг бэхжүүлэхэд шаардлагатай дэмжлэг бий болгоно" гэсэн 3.3 дугаар зорилтыг дэвшүүлсэн бөгөөд энэ хүрээнд Авлигатай тэмцэх зорилго бүхий иргэний нийгмийн байгууллагын сүлжээ, иргэдийн сайн дурын

			үзүүлэлтийн дагуу тайлагнаагүй. 2.Хөтөлбөрийн хэрэгжилт гэх баримт байхгүй, хүрсэн түвшинг шалгуур үзүүлэлтийн дагуу тайлагнаагүй тул 0 гэж үзсэн.	хөдөлгөөнийг дэмжих арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр АТҮХ-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан. Архангай аймгийн ЗДТГ нь аймгийн хуульчдын холбооны салбар зөвлөлтэй хамтран өдөрлөг зохион байгуулснаас өөр арга хэмжээг хэрэгжүүлээгүй, арга хэмжээг агуулгын хүрээнд тайлагнаагүй байх тул хяналтын үнэлгээг бууруулан үнэлэв. Цаашид тухайн арга хэмжээний хэрэгжилтийг тайлагнахдаа хамтран ажилласан иргэний нийгмийн байгууллага авлигатай тэмцэх зорилго бүхий гэдгийг онцлон, авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ямар арга хэмжээг хэрэгжүүлж, ямар үр дүнд хүрсэн, шалгуур үзүүлэлтийг хэрхэн хангасан талаарх мэдээллийг нотлох баримтын хамт цахим системд оруулахад анхаарах хэрэгтэй.
3.3.1.5. "Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам"-ыг хэрэгжүүлэхэд төрийн байгууллагад дэмжлэг үзүүлэх, олон нийтийн хяналт хэрэгжүүлэх этгээдийг чадавхжуулах	Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөл нь "Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам"-нд заасны дагуу сонгон шалгаруулалтыг зохион байгуулаагүй байна. Манай байгууллагын зүгээс аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлд хяналтын чиглэлийг тодорхойлон хүргүүлсэн болно.	30%	0% Тайлбар: 1.Засгийн газрын 2021 оны 109-р тогтоолоор батлагдсан журмын дагуу хийсэн гэх үйл ажиллагааны тайлагнал байхгүй. Зөвхөн тус журмын 4.2-т дурдсан асуудлаар ГХУСАЗСЗ-д чиглэл өгсөн гэсэн ганц ажлыг тусгасан нь шалгуур үзүүлэлтэд нийцэхгүй байна. 2.Шалгуур үзүүлэлтэд тусгасан 22 арга	0% Тайлбар: "Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам"-д тухайн байгууллага хяналт хэрэгжүүлэх шаардлагатай чиглэлээ тодорхойлж, хөндлөнгийн этгээдийг шалгаруулан тодорхой ажлыг гүйцэтгүүлэхээр тусгасан. Архангай аймгийн ЗДТГ тухайн арга хэмжээг хэрэгжүүлээгүй байх тул хяналтын үнэлгээг хэвээр үлдээв. Цаашид дээрх Журамд заасан арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд анхаарч, төрийн байгууллага, албан тушаалтан ямар үйл ажиллагаандаа олон нийтийн

			хэмжээнээс хэрэгжүүлсэн гэх ажил тайлагнаагүй, баримт байхгүй. Хавсаргасан баримт нь журамд хамаарахгүй соён гэгээрүүлэх чиглэлийн өөр ажлын мэдээлэл байсан тул хэрэгжилт байхгүй буюу 0 гэж үнэлсэн.	хяналтыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулсан, ямар үр дүн гарсныг шалгуур үзүүлэлтийг баримтлан тайлагнах шаардлагатай.
6.4.11.1. Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг бүрэн хангах	Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн чиглэлийн дагуу 2024 оны А/154 дүгээр захирамжаар аймгийн 2024 оны "Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө"-г баталсан. Архангай аймгийн авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх 3 үйл ажиллагааны 11 арга хэмжээний хэрэгжилтийн биелэлтэд хяналт тавьж ажилласан. Тус 11 арга хэмжээнээс 9 арга хэмжээ 100 хувь, 1 арга хэмжээ 70 хувь. 1 арга хэмжээ 30 хувь. Нийт хэрэгжилтийн дундаж 90.9 хувьтай хэрэгжсэн гэж дүгнэгдсэн байна.	90.91%	90% Тайлбар: 1.Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланд хийсэн ХШҮ-ний тайланг хавсаргасан. Мөн АЗД-ын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн тэмдэглэл ирүүлсэн тул өөрсдийн үнэлгээг нь бага зэрэг бууруулан үнэлсэн. 2.Төлөвлөгөө, тайланг нь тодруулан үзсэн тул үнэлгээг 90 хувиар авсан. 3.Цаашид анхаарах асуудлаа илүү бодьтой тодорхойлох шаардлагатай.	70% Тайлбар: - Арга хэмжээний хэрэгжилтийн хүрсэн түвшин нь зорилтот түвшинд хүрээгүй байна. - Арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэлийг сайжруулах шаардлагатай. - Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд АТГ-ын УССГХ-ээс хийсэн үнэлгээтэй дүйцүүлэн Хяналтын үнэлгээг өөрчлөв.
7.1.2.1. Төсвийн орлого, зарлагын мэдээллийг эдийн засгийн болон зориулалтын ангиллаар харуулах тусгах	Архангай аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч болон сумдын ерөнхийлөн захирагч, төсвийн шууд захирагч нар "Шилэн дансны тухай хууль"-ын хэрэгжилтийг аймгийн хэмжээнд 99 хувьтай хангаж ажиллаж байгаа бөгөөд шилэн дансны мэдээлэл болон аудитын байгууллагын зөвлөмжийг ил тод мэдээллэж байна. Архангай аймаг 2024 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 105,2 тэрбум төгрөгийн 30 төсөл арга хэмжээг шинээр, аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 8,8 тэрбум төгрөгийн 36 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж байна. Дээрх 66 төсөл арга хэмжээний төлөвлөлтийг 2023 онд сум, агентлагийн саналыг авч нэгтгэн, иргэн, иргэний нийгмийн байгууллагаас санал авч, ажлын хэсгээс эрэмбэлэн улсын төсөв болон аймаг, орон нутгийн төсөвт тусган	100%	Үнэлгээнээс хасаж тооцов.	Үнэлгээнээс хасаж тооцов. Тайлбар: Тус арга хэмжээний шалгуур үзүүлэлт Төсвийн нээлттэй байдлын судалгааг үндэслэн гарч байгаа. Төсвийн нээлттэй байдлын олон улсын судалгаа нь улсын төсвийн ил тод байдал, төсвийн ерөнхийлөг захирагчдын төсөв, сангийн яамны төсвийн процесс, үндэсний аудитын

	хэрэгжүүлж байна. 2025 оны орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтыг Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөнд уялдуулан боловсруулж, 2024 оны 11 дүгээр сарын 20, 21-ний өдрүүдэд салбар байгууллага болон олон нийтэд нээлттэй хэлэлцүүлгийг зохион байгуулан 17 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан. Мөн улсын төсвийн болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хүрээнд 100 хувь цахимаар ил тод, нээлттэйгээр зохион байгуулан ажилласан.			байгууллагын хяналт зэрэг байгууллагуудын тоо мэдээ, мэдээлэлд үндэслэн гаргадаг. Тиймээс аймаг, нийслэлийн түвшинд үнэлгээ хийхгүй тул үнэлгээнээс хасаж тооцов.
7.1.2.2. Төсвийн тухай хууль дахь төсвийн ерөнхийлөн захирагч болон төсвийн шууд захирагч гэсэн ерөнхий мэдээллийг байгууллага тус бүрээр албан тушаал, нэрээр ил тод тодорхой болгох нэр тус бүрээр ил тод, тодорхой мэдээлэх	Архангай аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч болон сумдын ерөнхийлөн захирагч, төсвийн шууд захирагч нар "Шилэн дансны тухай хууль"-ын хэрэгжилтийг аймгийн хэмжээнд 99 хувьтай хангаж ажиллаж байгаа бөгөөд шилэн дансны мэдээлэл болон аудитын байгууллагын зөвлөмжийг ил тод мэдээллэж байна. Мөн shilendans.gov.mn цахим сайтад төсвийн ерөнхийлөн захирагч болон төсвийн шууд захирагч гэсэн ерөнхий мэдээллийг байгууллага тус бүрээр албан тушаал, нэрээр ил тод тодорхой мэдээлж байна.	100%	Үнэлгээнээс хасаж тооцов.	Үнэлгээнээс хасаж тооцов. Тайлбар: Төсвийн нээлттэй байдлын олон улсын судалгаа нь аймаг, нийслэлийн түвшинд үнэлгээ хийхгүй тул үнэлгээнээс хасаж тооцов.
9.2.1.1. Үндэсний контентыг бүтээх	Байгууллагын үйл ажиллагаанд авлигад өртөж болзошгүй чиглэлийг сонгон авлигын эрсдлээс ангид байхад чиглэсэн, ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий видео контент бүтээх удирдамжийг боловсруулан аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч 27 агентлаг, 19 сумдад хүргүүлж, иргэд олон нийтэд сурталчилан ажиллах чиглэл өгсөн. Сум, агентлагаас хийсэн видео шторкийг аймгийн Засаг даргын тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн фэйсбүүк пэйж хуудсаар иргэд, олон нийтэд түгээн ажиллалаа.	100%	90% Тайлбар: Үндэсний хэмжээний контентуудыг хэрхэн түгээн дэлгэрүүлэх чиглэлээр хийсэн ажлын тайлагнал, баримт байхгүй боловч олон нийтэд сурталчлах чиглэлийн ажлын хүрээнд орон нутгийнхаа боломжид тулгуурлан уралдаан зарлаж хийсэн ажлыг нь 90 хувь гэж үнэлсэн.	90% Тайлбар: Үндсэн шалгуур үзүүлэлт болох авлигыг үл тэвчих үзлийг олон нийтэд төлөвшүүлэх зорилго бүхий үндэсний контентыг бүтээж түгээсэн тул үнэлгээг хэвээр баталгаажуулав.
9.2.2.1. Авлигыг үл тэвчих үзлийг түгээн дэлгэрүүлэхэд соёл, урлаг, спорт, хэвлэл мэдээллийн оролцоог нэмэгдүүлж, мэдээлэл солилцох сувгийг хөгжүүлэх	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хэрэгжилтийн хүрээнд Архангай аймагт үйл ажиллагаа явуулдаг хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллах гэрээг байгуулж "Авлигын эсрэг хууль"-ийн талаарх мэдээ мэдээлэл, Авлигатай тэмцэх газраас соён гэгээрүүлэх чиглэлээр бэлтгэсэн контентуудыг орон	100%	70% Тайлбар: 1.Шалгуур үзүүлэлтэд хамаарах хуулийн этгээд, хувь хүний тоог тодорхойлсон тайлагнал	70% Тайлбар: Уг арга хэмжээг хариуцсан байгууллагууд авлигын эсрэг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг дангаар зохион байгуулахаас гадна уг үйл

	нутгийн "АВ", "Тамир" телевиз, цахим хуудсаар дамжуулан иргэд олон нийтэд хүргэсэн.		байхгүй, баримт хавсаргаагүй. 2.Зөвхөн хэвлэл мэдээллийн хэрэгслийг татан оролцуулсан тухай мэдээлэл тусгасан нь тайлагнал хангалтгүй. Баримт мэдээлэл дутуу тул үнэлгээг 70 болгож бууруулсан.	ажиллагаанд соёл урлаг, хэвлэл мэдээллийн болон бусад салбарын төлөөллийг зохион байгуулалтад татан оролцуулах нь илүү үр дүн гаргах ач холбогдолтой. Архангай аймгийн ЗДТГ нь уг арга хэмжээнд 2 телевизийг мэдээлэл дамжуулагч байдлаар оролцуулсан нь хангалтгүй байна. Цаашид шалгуур үзүүлэлтийн дагуу холбогдох салбарын төлөөллийг идэвхтэй байдлаар татан оролцуулах, тайлагналыг тоо баримттай, нотолгоотой гаргаж байх шаардлагатай.
9.3.3.1. Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд иргэний нийгмийн оролцоо, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх	Хүний эрхийн Үндэсний Комиссын Архангай аймаг дахь референт, Насан туршийн суралцахуйн төвтэй хамтран "Хүний эрхийн тухай ярилцъя" "Авилгын тухай ойлголт, илгэх хэлбэр, хор хөнөөл" сэдэвт өглөөний уулзалтыг 2024 оны 05 дугаар сарын 24-ний өдөр зохион байгууллаа. Тус уулзалтад Төрийн бус байгууллагын төлөөллөөс өөрсдөө болон манай аймагт тулгамдаж буй асуудлуудыг хөндөж, агентлаг байгууллагууд чиг үүргийнхээ хүрээнд хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах талаар мэдээллийг өгсөн. 2024 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжих 3-р сургуулийн өргөтгөл, Төвшрүүлэх сумын 100 хүүхдийн дотуур байр, Эрдэнэбулган сумын 6 багийн спорт заал, Өгийнуур, Хашаат сумын 150 хүүхдийн цэцэрлэг, Эрдэнэбулган сумын 3, 5, 14 дүгээр цэцэрлэгийн барилгын зураг төсөл боловсруулах шатанд Тэгш тусгал төрийн бус байгууллагатай хамтран үзлэг хийж холбогдох зургийн компанид зөвлөмж хүргүүлэн ажиллалаа. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоодын зөвлөлөөс "Бидний оролцоо-Бидний боломж" арга хэмжээг 2024 оны 12 дугаар сард зохион байгуулж 2024-2028 оны Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд хийж хэрэгжүүлэх ажлын жагсаалтанд санал өгсөн. Энэ онд шинээр ашиглалтад орсон 15 барилга байгууламжийн комисст Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоодын зөвлөлийн тэргүүн Г.Самбууданзан оролцож Монгол улсын MNS 5682:2006 "Явган хүн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан зам", MNS 6055:2009 "Иргэний барилгын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчин" зэрэг стандартуудын холбогдох үзүүлэлт шаардлагуудын хэрэгжилтэд, бодит нөхцөл байдал дээр нь очиж үнэлгээ хийн, үүрэг даалгавар өгч ажилласан. Барилга байгууламжийн зураг төсөл, ажлын даалгаварт хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан тусгай шаардлага, холбогдох норм ба дүрэм, стандартуудыг тусгаж, хэрэгжүүлэх, хяналт тавин ажилсанаараа орон сууцны болон бусад төрлийн барилгын норм,	100%	70% Тайлбар: 1.Төлөвлөсөн арга хэмжээний агуулгаас өөр төрлийн үйл ажиллагааг түлхүү тайлагнасан. Хавсаргасан баримт шаардлага хангахгүй, 2.Шалгуур үзүүлэлтийг хэрхэн хангаж ажилласан тухай мэдээлэл тайланд тусгагдаагүй. 3.Тайлагнал дутуу тул үнэлгээг бууруулсан.	50% Тайлбар: Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх арга хэмжээг өргөн хүрээнд зохион байгуулж, эдгээр ажилдаа иргэний нийгэм, иргэд, төрийн бус байгууллагын төлөөллийг идэвхтэй оролцуулах, хамтран ажиллах шаардлагатай. Мөн энэ чиглэлээр иргэний нийгэм, иргэдийн санал, санаачлагыг дэмжин ажиллах шаардлагатай. Бусад байгууллагуудын хувьд иргэний нийгэмтэй хамтран авлигаас урьдчилан сэргийлэх сургалт, судалгаа, уулзалт, хэлэлцүүлэг, уралдаан зохион байгуулж байгааг анхаарах. Тайланд тусгасан ажлуудаас зөвхөн нэг ажил буюу "Авлигын тухай ойлголт, хор хөнөөл" сэдэвт өглөөний уулзалт нь авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажилд хамаарч, бусад ажил нь хүний эрхийг хамгаалах зорилготой ажлууд байна. Гүйцэтгэлийг тодорхой хэмжээнд

	нормативын баримт бичгийн мөрдүүлэлт, чанар, аюулгүй байдал сайжирсан байна.			хүргэсэн гэж үзэх үндэслэлгүй байх тул үнэлгээг бууруулав.
9.4.2.1. Хүүхдэд үл тохирох контентын хязгаарлалт бий болгож хэрэгжүүлэх	Архангай аймгийн Засаг даргын тамгын газар, Төрийн цахим үйлчилгээний хэлтэстэй хамтран төрийн албан хаагчид, ерөнхий боловсролын сургуулийн сурагчид болон иргэдэд цахим ур чадвар олгох сургалтыг үе шаттайгаар хэрэгжүүлэн ажиллаж байна. Энэ хүрээнд Архангай аймгийн Ерөнхий боловсролын 5-н сургуулийн 554 сурагчдад, Боловсролын яамны харьяа Архангай аймаг дахь политехникийн коллежийн 50 оюутнуудад хөтөлбөрийн дагуу сургалт зохион байгуулсан. Сургалтаар "Кибер аюулгүй байдлын өнөөгийн нөхцөл байдал" "Цахим залилангаас урьдчилан сэргийлэх" "Эцэг эхийн хяналтын программ (e-kids)" "Цахим орчин дахь донтолт сэтгэл зүйн нөлөөлөл" гэсэн сэдвүүдийн дагуу сургалт зохион байгуулсан байна.	100%	70% Тайлбар: 1.Арга хэмжээ нь аймгийн түвшинд хариуцан хийх ажил биш ч цахим ур чадварыг сайжруулах чиглэлийн ажлуудыг тайлагнаж зураг бүхий баримт хавсаргасан тул 90 хувьтай гэж үнэлсэн. 2.Хүүхдэд үл тохирох контентын хязгаарлалтыг хэрхэн сурталчлан хэрэгжүүлж ажилласан талаар тайланд дурьдах шаардлагатай байсан.	50% Тайлбар: Энэ арга хэмжээний хүрээнд хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хүүхдэд үл тохирох контентын хязгаарлалт тогтоосон зохицуулалтыг хэрэгжүүлэх, орон нутгийн хэмжээнд хүүхдэд үл тохирох контентын хязгаарлалтын зохицуулалтыг эрх хэмжээний хүрээнд тогтоож, мөрдүүлэх, үндэсний хэмжээнд хүүхдэд үл тохирох контентын хязгаарлалт тогтоох зорилгоор шинээр боловсруулж байгаа эрх зүйн актын төсөлд санал өгөх зэрэг ажлуудыг санаачлан хийх шаардлагатай. Хүүхдийн хүмүүжил, ёс суртахуун, шударга байдалд нөлөөлж байгаа цахим орчин дахь контентын агуулгад хяналт тавьж, хязгаарлалтыг хэрэгжүүлэх нь авлигын суурь шалтгааныг арилгах чухал ач холбогдолтой тул цаашид анхаарч ажиллах шаардлагатай. Гүйцэтгэл хангалтгүй байна. Гүйцэтгэлийг тодорхой хэмжээнд хүргэсэн гэж үзэх үндэслэлгүй тул ажлыг тодорхой хэмжээнд эхлүүлсэн гэж үзэж үнэлгээг бууруулав.
9.4.3.1. Хүүхдийн шударга байдалд сөргөөр нөлөөлж байгаа хүчин зүйлсэд дүн шинжилгээ хийх	Аймгийн Засаг даргын ивээл дор "ОЛУУЛАА ОРОЛЦЬЕ, ХӨГЖЬЕ, ӨӨРЧИЛЬЕ" аймгийн хүүхдийн VII дугаар чуулганыг "Тамир" зусланд зохион байгуулсан. Чуулганд Архангай, Өвөрхангай, Улаанбаатар хотын 130 төлөөлөгч хүүхэд оролцсон. "Хүүхдийн хөгжих эрх", "Хүүхдийн хамгаалуулах эрх", "Хүүхдийн эсэн мэнд амьдрах эрх", "Хүүхдийн оролцох эрх" гэсэн 4 үндсэн чиглэлээр салбар хэлэлцүүлэг зохион байгуулж дүн шинжилгээ хийж, чуулганы төлөөлөгч хүүхдүүд хүүхдийн	100%	30% Тайлбар: 1.Хүүхдийн шударга байдалд сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлсэд дүн шинжилгээ хийх ажил	30% Тайлбар: Арга хэмжээний үндсэн шалгуур үзүүлэлт нь хүүхдийн шударга байдалд нөлөөлж байгаа хүчин зүйлд дүн шинжилгээ хийсэн байх, хийсэн талаараа тодорхой нотолгоог

	төлөө үүрэг хүлээгч, эцэг эх асран хамгаалагч нарт хандаж зөвлөмж гаргасан байна.		хийгдээгүй. Холбогдох баримт байхгүй. 2.Хүүхдийн чуулган хийсэн өөр ажлыг тайлагнасан тул үнэлгээг бууруулсан.	тайланд хавсаргасан байх шаардлагатай. АТГ-аас жил бүр Хүүхдийн шударга байдлын судалгааг зохион байгуулж дүнг нийтэд танилцуулдаг. Судалгаанд хамрагдсан аймаг, дүүргийн дүн ялгаатай гардаг тул аймаг, орон нутгийн хэмжээнд хүүхдийн шударга байдалд сөргөөр нөлөөлж байгаа онцлог, хүчин зүйлсэд дүн шинжилгээ хийж, гарсан үр дүн, дүгнэлтийн тодорхой ажил зохион байгуулах нь чухал.
9.5.2.1. Шүгэл үлээхийг дэмжих зорилгоор мэдээлэл өгөх суваг, хамгаалалтын арга хэлбэр, ач холбогдлын талаар олон нийтэд сурталчлах	"Авлигатай тэмцэх таван ажиллагаа"-ны нэг арга хэмжээ болох "Шүгэл ажиллагаа"-ны хүрээнд авлигын эсрэг үйл хэрэгт хүн бүрийн оролцоог нэмэгдүүлэх замаар хүнд суртал, чирэгдлийг бууруулах, авлигыг мэдээлж, шүгэл үлээхийг уриалсан соён гэгээрүүлэх "...Нэгдье" аянд нэгдэх "Шударга, зөв нийгмийн төлөө хамтдаа", "Авлига авлагатай" "Нийтийн албан тушаалтанд хориглох авлигын зөрчил", гэх сэдвээр, мөн Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан Авлигын гэмт хэргээр постер бэлтгэн аймгийн Засаг даргын тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн фэйсбүүк пэйж хуудас, лед дэлгэц, мэдээллийн самбарт байршуулж, давхардсан тоогоор 20,000 гаруй иргэд, олон нийтэд хүргэсэн. Аймгийн төвийн Эрдэнэбулган сумын ЗДТГ-с Авлигын хэлбэрийг сурталчилсан гарын авлага хийж, 1-7 багийн захиргаагаар дамжуулан 500 ширхгийг иргэдэд тараан ажилласан байна. Засаг даргын хэрэгжүүлэгч 27 агентлаг, 19 сумдад уриалж, Авлигатай тэмцэх газраас бэлтгэн ирүүлсэн аяны постер, контент, шторкийг тухай бүр өөрсдийн байгууллагын албан ёсны сайт болон фэйсбүүк пэйж хуудсанд байршуулж, давхардсан 20,000 гаруй тоогоор иргэд сурталчлан таниулсан.	100%	90% Тайлбар: Хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүнг бүрэн гүйцэт тайлагнаагүй, хавсаргасан баримт хангалтгүй тул үнэлгээг бууруулсан.	90% Тайлбар: Тайланд авлигын эсрэг сурталчилгааны ажлыг өргөн хүрээнд зохион байгуулсан талаар тайлагнасан боловч шүгэл үлээхийг дэмжих зорилгод чиглэгдсэн тухайлсан ямар арга хэмжээ авсан талаар тодорхой тусгаагүй, мөн хийсэн ажлын тодорхой нотолгоо хавсаргаагүй байна. Тиймээс тухайн арга хэмжээний хэрэгжилтийг 100 хувь гэж үнэлэх боломжгүй, мөн тайлангийн чанарын үнэлгээ хангалтгүй байна. Авлигын гэмт хэрэг, зөрчил, ашиг сонирхлын зөрчил, ёс зүйн зөрчлийг нийтэд мэдээлэх, хууль сахиулах байгууллагад болон бусад байгууллагад мэдээлэх, мэдэгдэх нь авлигатай тэмцэхэд чухал ач холбогдолтой. Ийнхүү шүгэл үлэхийн ач холбогдлыг олон нийтэд зөвөөр ойлгуулах, бусад шаардлагатай мэдээллийг хүргэх нь уг арга хэмжээг хариуцагч

				байгууллагуудын хүлээсэн үүрэг болно. Хэрэгжүүлэх арга замын хувьд байгууллагуудаас холбогдох контент, сургалт, сурталчилгааны материал боловсруулах, нийтэд хүргэх, сургалт, хэлэлцүүлэг, судалгаа хийх, эрх хэмжээний хүрээнд эрх зүйн акт баталж хэрэгжүүлэх зэрэг арга хэмжээг авч байна. Цаашид эрх зүйн зохицуулалт бий болохтой холбоотойгоор нийтэд сурталчлах ажлыг эрчимжүүлэх, салбар, орон нутаг, байгууллагын онцлогийг харгалзан ажлыг зохион байгуулах, санаачилгатай ажиллах шаардлагатай байна. Шүгэл үлээхийг дэмжих зорилгод чиглэгдсэн тухайлсан ямар арга хэмжээ авсан талаар тодорхой тусгаагүй, мөн хийсэн ажлын тодорхой нотолгоо хавсаргаагүй байна. Тиймээс тухайн арга хэмжээний хэрэгжилтийг 100 хувь гэж үнэлэх боломжгүй, мөн тайлангийн чанарын үнэлгээ хангалтгүй байна.
--	--	--	--	--

3. Аймаг, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Үнэлгээний эрэмбэ

Эрэмбэ	Аймаг	Оноо
1	Дархан-Уул аймгийн ЗДТГ	65.4
2	Баянхонгор аймгийн ЗДТГ	64.5
	Хөвсгөл аймгийн ЗДТГ	64.5
3	Орхон аймгийн ЗДТГ	62.7
4	Булган аймгийн ЗДТГ	59.1
5	Өвөрхангай аймгийн ЗДТГ	55.4
6	Говьсүмбэр аймгийн ЗДТГ	54.6
7	Нийслэлийн ЗДТГ	53.4
8	Завхан аймгийн ЗДТГ	48.3
9	Архангай аймгийн ЗДТГ	48.2
10	Дорноговь аймгийн ЗДТГ	45.5
11	Дундговь аймгийн ЗДТГ	44.6
12	Дорнод аймгийн ЗДТГ	43.6
13	Өмнөговь аймгийн ЗДТГ	40.8
14	Баян-Өлгий аймгийн ЗДТГ	32.5
15	Ховд аймгийн ЗДТГ	30.8
	Хэнтий аймгийн ЗДТГ	30.8
16	Говь-Алтай аймгийн ЗДТГ	26.4
17	Төв аймгийн ЗДТГ	24.2
18	Сүхбаатар аймгийн ЗДТГ	20.9
19	Сэлэнгэ аймгийн ЗДТГ	20.0
20	Увс аймгийн ЗДТГ	15.0
Дундаж оноо		43.2

---oOo---